

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



# ӨВӨРХАНГАЙ

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Өвөрхангай аймаг нь БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор 31 сумтай анх байгуулагдсан.

Аймгийн төв: Арвайхээр хот

Хэдэн сумтай: 19

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 62,895.33 км<sup>2</sup>

Хүн ам: 113,157 (2016 он)

Угсаатан: Халх

Малын тоо толгой: 2,010,600

Утасны код: +976 (0)132

Шуудангийн дугаар: 62000

ТХ-ийн улсын дугаар: ӨВ

Цахим хуудас: [www.uvurkhangai.mn](http://www.uvurkhangai.mn)

Нутгийн хойд хэсэгт хангайн нурууны салбар уулс, төв хэсгээр нь хөндийн тал, өмнө хэсгээр нь Алтай нурууны салбар уулс, элсэрхэг тал хээрийн нутагтай. Хангайн нурууны Хятруун, Битүүт, Монгол Алтайн нурууны Багабогд, Мянган ямаат зэрэг далайн түвшнээс дээш 2000-3590 м өндөрт өргөгдсөн сүрлэг уул, нурууд оршдог. Арвайхээр, Шагж, Долоодой, Хонгор, Гучингийн тал болон Орхоны хөндий зэрэг тэгш удам талууд бий. Өвөрхангай аймгийн өмнөд хэсэг нь Говь-Алтайн нурууны өвөрийн уулархаг, өмнөд хэсэг нь тал хөндий бөгөөд Багабогд, Арцбогд уулууд оршдог.

Өвөрхангай аймгийн нутгаар Орхон, Онги, Таац, Ар агуй зэрэг том голууд урсах бөгөөд Найман нуур, Таацын Цагаан нуур зэрэг нууруудтай.

Нутгийн хойд хэсэгт хангайн их хөвч, тайга, зүүн хэсгээр хээрийн бүсийн, өмнө хэсгээр говийн ургамал тархжээ. Хангайд буга, бор гөрөөс, тал хээрт үнэг, чоно, хярс, мануул, говьд аргаль, янгир, цагаан зээр, хар сүүлт, хойлог зэрэг ан амьтан элбэгтэй бөгөөд дэлхийн улаан номонд бичигдсэн дархан цаазат хулан, ирвэс ч байдаг.



# АРВАЙХЭЭР

ХОТЫН ТУХАЙ



Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу, хожмын Цэцэрлэг мандал аймгийн Арвайхээрийн хошууг 1707 онд сайн ноён Жамбын 2 дугаар хүү Цэрэндашид Сайн ноёны хошуунаас хошуу таслан өгч байгуулжээ. 1726-1727 оны үед Ганданпунцоглин хийд анх удаа Дэлгэрэхийн эхэнд модон дуган барьж, суурьшсанаар Арвайхээр хотын үүсэл хөгжлийн эхлэлийг эрдэмтэн, мэргэд тодорхойлсон байдаг.

Өрхийн тоо: 8284

Хүн амын тоо: 28,722

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 430 км



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
**ДЭЛХИЙН ӨВ,  
ОРХОН ГОЛЫН НҮҮДЭЛЧИД**  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Өвөрхангай аймгийн “ДЭЛХИЙН ӨВ, ОРХОН ГОЛЫН НҮҮДЭЛЧИД” аялал жуулчлалын холбоо нь тус аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг хариуцлагатай, тогтвортой аялал жуулчлал эрхлэх, орон нутгийн иргэдийн амьжиргаанд тус дэм болоход нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллах зорилготой.

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

## Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрут

*/Байгаль, түүх, шашин мөргөлийн  
аяллын төрөлд хамаарна/*

**Чиглэл нь:**

Элсэн тасархай - Их, Бага Монгол  
уул - Ширээт цагаан нуур - Монгол  
орны төв хүйс - Хархорин,  
Эрдэнэзуу - Шанхын хийд -  
Хужирт сум - Үүртийн тохой -  
Төвхөн хийд - Улаанцутгалан -  
Хужирт сум

## Хүйсийн найман нуур буюу тусгай сонирхлын аяллын маршрут

*/Морь болон явганаар хийх аялал/*

**Чиглэл нь:**

Ширээт нуур – Халиут нуур – Бугат  
нуур – Хаяа нуур – Хүйс нуур –  
Онон нуур – Дөрөө нуур -  
Баян-Уулын нуур

## Говийн болон баруун бүсийн сумдын аяллын маршрут

*/Байгаль, түүх соёл,  
палентлогийн аяллын төрөл/*

**Чиглэл нь:**

Арвайхээр - Мазар хотын туурь -  
Өөш Шахлага - Арц богдын нуруу  
- Зүүн богд уул - Эмч элс - Таацын  
цагаан нуур - Өшгөгийн их залаа -  
Өнц шилүүстэй - Шаргын тасархай  
- Шаамын рашаан - Хубилай  
хааны цэргийн хотын үлдэгдэл -  
Ширээт нуур - Арвайхээр

## Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрут

*/түүх, соёл, шашин мөргөлийн  
аялал/*

**Чиглэл нь:**

Занабазарын нэрэмжит дүрслэх  
урлагын музей - Элсэн тасархай -  
Их, Бага Монгол уул - Ширээт  
цагаан нуур - Монгол нутгийн хүйс  
цэг - Өндөр гэгээний Өвгөн  
суварга - Сэрүүн булаг - Есөн Зүйл  
сум - Сангийн далай нуур –  
Арвайхээр - Занабазарын  
нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн -  
Бат-Өлзий сум – Улаанцутгалан -  
Төвхөн хийд - Баруун хүрээ -  
Эрдэнэзуу хийд - Хөгнө тарнийн  
хийд

# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **АРЦ БОГД УУЛ**

Өвөрхангай аймгийн Богд сумын нутагт орших Арц богд уул нь Бага Богд уулын зүүн хоолойгоор зааглагдаж, баруун үзүүр нь Бага Богд уултай 20 гаруй километр газраар зөрсөн байдаг. Уулсын ар тал нь эгц, нилээд хадархаг говийн шинжтэй. Ноён оргил нь далайн төвшнөөс дээш 2477 метр өндөр Их баян уул. Уулын өвөр тал нь нилээд налуу, олон салбар уулстай. Тухайлбал, Дулаан богд уул 2094 метр, Зост уул 1580 метр, салбар уулсын зүүн хэсэг нь Халзан хайрхан уулаар төгсдөг. Ийнхүү Арц Богд уул нь салбар уулсын хамт 180 километр үргэлжилдэг. Зүүн өвөрт нь Их булаг, Бага булаг, Бумба, Сөөг, Туруухай, Цагаан хад, Баруун Зүүн хөөвөр гэх мэт задгай устай. Харин баруун өвөртөө Авдрантай, Зүүн баруун Ялаатай, Гэгээт, Ямаан ус, Харангад, Хөөвөр, Мансруй зэрэг задгай устай. Ийм их гол горхи булаг шандтай учраас Арц богд ууланд жилийн дөрвөн улиралд манан татаж, хур буун эдгээр усан сангуудаа эргээд усаар тэтгэж байдаг, алтан дуулгат хайрхан юм.



# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХАРХОРИН**

Хархорум (Хархүрэм) буюу Каракорум хот нь Чингис хааны зарлигаар 1220 онд Их Монгол улсын нийслэл хотыг Аураг ордноос тус хотод шилжүүлэх зарлиг гарч, Өгэдэй хааны үеэс албан ёсны нийслэл юм. XIII зууны үед байгуулагдсан бөгөөд уг хот нь Мин улсаас явуулсан довтолгооны үр дүнд сүйдсэн. Сүүлийн жилүүдэд төр засаг болон ард түмний дунд уг хотын байсан газарт шинэ хот үүсгэн байгуулж нийслэл хот болгох санал санаачлага гарч байсан болно. Хар Хорум хотыг 1220 онд Чингис хаан үндэслэж. Хубилай хааны үед барин дуусгажээ. Тэнд хот суурин анх байгуулагдсан нь VIII зууны (Уйгур улс) үед холбогддог. Чингис хааны үед Хар Хорум нь цэрэг зэвсгийн агуулах суурин шинжтэй байжээ. 1232 онд Хархорумын гол хэрмийг байгуулжээ. 1235 онд хаант төрийн сүр хүч, хөгжил цэцэглэлтийн илэрхийлэл болгон Түмэн Амгалант ордныг байгуулснаар Хархорум хот улам ч өнгө жавхаатай болжээ. Түүний өмнөхөн Өгөөдэй хаан ор суусны 7-р он хөхөгчин хонин жил (1235 он)-ийн хавар Хархорум хотыг цогцлон байгуулж Түмэн Амгалант ордныг барьж, 8-р оны (1236 он) улаан бичин жилийн цагаан сард олон ван ноёд зоог базаан уг ордныг барьж гүйцсэнд зориулж их найр, хурим ёслол үйлджээ. Ийнхүү Өгэдэй хаан Хархорумын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулснаар Монголын эзэнт гүрний нийслэлийн өнгө төрхийг илэрхийлэхүйц хот болсон байна.



# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ЭРДЭНЭЗУУ

Эрдэнэ зуу хийд нь Монгол Улс дахь хамгийн эртний Бурханы шашны хийд юм. Тус хийд нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвийн ойролцоо, эртний хот Хархорумын туурийн хажууд байрладаг. Энэ хийд Дэлхийн өвд бүртгэгдсэн Орхоны хөндийн соёлын дурсгалд багтдаг. 1580 онд Абатай сайн хан, дүү Түмэнхэн ноёны хамт Гуравдугаар Далай ламтай уулзаж өөрийн нутагт сүм хийд байгуулахаа амласанд, Далай лам Хархорум хотын нэгэн хуучин сүмийг сэргээхийг зөвлөсний дагуу 1585 онд эртний Тахай балгасан дахь сүмийг сэргээн босгож дуусгасан нь[1] одоогийн Эрдэнэзуу хийдийн гол зуу сүм гэж Өндөр гэгээний намтар хэмээх гар бичмэлд бичжээ. Ийнхүү хийд босгоход Хархорум хотын туурийн чулууг ашигласан байдаг. 1939 онд коммунист удирдагч Хорлоогийн Чойбалсангийн удирдлага дор Монголын олон зуун сүм хийдийг устгаж, арван мянга гаруй ламыг хядсан их хядлага энэ хийдийг тойрсонгүй. Гурван жижиг сүм, суврагууд бүхий гадна хана л үлдсэн бөгөөд сүмүүдийг 1947 онд музей болгожээ. Энэ хийдийг Иосиф Сталины шахалтаар Гандантэгчилэн хийдтэй хамт үлдээсэн гэх нь бий. Учир нь, нэг судлаачийн үзэж байгаагаар 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч Хэнри А. Воллес тэргүүтэй төлөөлөгчид Монголд богино хугацааны айлчлал хийсэнтэй энэхүү явдал холбоотой ажээ.





# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ТӨВХӨН ХИЙД

Төвхөн хийд нь Өвөрхангай, Архангай аймгуудын заагт, Хужирт сумын төвөөс баруун хойш 40 км зайд Орхоны хөндийд орших, Монголын Буддын шашны хамгийн эртний хийдүүдийн нэг юм. 1648 онд анхдугаар Жавзандамба хутагт, өндөр гэгээн Занабазар 14 настайдаа далайн түвшнээс дээш 2,600 метр өргөгдсөн Ширээт Улаан уулын оройд, ой модоор хүрээлэгдсэн аглаг ойн байц хадтай бяцхан дэвсгийн онцгой тогтцыг таалж, улмаар 1651 онд Төвөдөөс эргэн ирээд уг газарт бясалгалын дуган бариулжээ. Түүнийгээ "Дубхан" буюу бүтээх байр хэмээн нэрлэсэн нь сунжирсаар "Төвхөн" гэгдэх болсон түүхтэй. Занабазар Төвхөн хийдэд сууж байхдаа соёмбо үсгийг зохиосон. Хийд Халх-Ойрадын самуунд өртөж, 1688 онд сүйтгэгдсэн бөгөөд 1773 оноос хурал номын ажлыг нь сэргээж тогтмолжуулаад байсан нь 1939 онд Их хэлмэгдүүлэлтийн үеэр тасалджээ. 1992 онд улсын хамгаалалтад авч, сүмийн үйл ажиллагааг сэргээсэн бөгөөд 1997 онд сэргээн засварлалтын ажил өндөрлөсөн.




# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### УЛААНЦУТГАЛАН

Монгол улсын Өвөрхангай аймгийн нутагт, Орхон голд цутгах Улаан гол дээрх хүрхрээ. Хүрхрээний өндөр — 24 метр. Хархориноос урагш 135 км зайтай. Улаан цутгалангийн хүрхрээ нь Монгол орны аялал жуулчлалын гол зорин очих газруудын нэг юм. Уг хүрхрээ нь сумын төвөөс баруун тийш 30 орчим километрийн зайтай, 20 гаруй метрийн өндөрөөс буух 5 орчим метр өргөнтэй хүрхрээ юм. Үүнийг зарим хүн “Орхоны хүрхрээ” хэмээн нэрлэх тохиолдол байдаг. Гэвч энэ нь ташаа нэрлэлт юм. Учир нь Хангай нуруу, тухайлбал Хятруун болон Улаанаас эх авсан Хятруун болон Улааны гол Орхон голд цутгахдаа уг хүрхрээг үүсгэжээ. Орхон гол нь Өндөр хясааны талаас Онгоцотын ам хүртэл 50 орчим километр газар ойролцоогоор 20 орчим метрийн өндөртэй хадан хавцал дундуур урсдаг. Энэ хавцал руу Улаан гол буухдаа уг хүрхрээг үүсгэжээ. Голын ус доош буухдаа хүрмэн чулуун тавцанг идэн ухарсаар Орхон голоос 100 орчим метр холдож, 10 орчим метр гүн цүнхэл үүсгэсэн байна. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт Улаан цутгалангаас гадна “Орхоны хүрхрээ буюу бага цутгалан”, “Татуурын хүрхрээ”, “Цагаан голын хүрхрээ” хэмээх том жижиг нийлсэн дөрөв таван хүрхрээ буй.



# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХҮЙСИЙН НАЙМАН НУУР**

Хүйсийн найман нуур нь Өвөрхангай аймгийн Уянга, Бат-Өлзий сумын нутагт орших далайн түвшнээс дээш 2800-3170 метрийн өндөрт байрладаг сүрлэг уулсын дунд орших Ширээт, Халиут, Бугат, Хаяа, Хүйс, Шанага, Дөрөө, Баян хэмээх нуураас бүрдсэн байгалийн хосгүй үзэсгэлэнт газар билээ. Хүйсийн найман нуур нь гүний судлаар холбоотой бөгөөд цэнгэг усны арвин баялаг сан аж. Эргэн тойронд нь Урт жалгын тогоо, Довын тогоо, Ар битүүтийн тогоо, Ногоон нуурын тогоо нэртэй сөнөсөн галт уулын тогоонууд байдаг. Мөн нуурыг хүрээлж хус, шинэс зэрэг шилмүүслэг мод зонхилсон их хөвч тайга бүхий сүрлэг уулс бий. Тус газарт 18 зүйлийн хөхтөн, 39 зүйлийн шувуу амьдардаг төдийгүй манай улсад ховор байдаг олон төрлийн эмийн ургамал ургадаг юм байна. Хүйсийн найман нуурыг 1995 онд "Байгалийн дурсгалт газар" хэмээн зарлаж Улсын тусгай хамгаалалтад авсан юм.



# ҮЗМЭРҮҮД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ТЭВШ УУЛ

Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг, сумын төвийн дэргэд зүүн хойд зүгт салбарлан тогтсон хар уулыг тэвш уул гэж нэрлэнэ. Тэвш уулын эргэн тойронд олон төрлийн хадны сүг зураг байхаас гадны булш хэрэгсүүрүүд ч олон байна. Сүүлийн жилүүдэд Хонгорын элсийг зорих аялагч жуулчид Тэвш ууланд саатан хадны сүг зураг дүрслэлийг үзэж сонирхох нь их болсон. Тэвш уулын хадны зурагт элдэв ан амьтан, анчин гөрөөчин, мал аж ахуй, хүмүүсийн амдрал ахуйг харуулсан зургууд голлоно. Ан амьтдын дотроос буга, янгир, тэмээ, адуу, нохой зэргийг хаданд хонхойлон дүрслэсэн байдаг. Ахуй амьдралтай холбоотой зургууд үхэрт нуруу ачсан, ямар нэгэн зүйлийг чирүүлсэн, морь хөтөлсөн хүн, морьтой болон явган хүмүүс адуу малыг тууж яваагаар дүрслэсэн байна.



# БУСАД ҮЗМЭРҮҮД



## ЭЛСЭН ТАСАРХАЙ

Төв аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Бүрд, Булган аймгийн Рашаант сумдын нутгийг дамнан Батхаан уулын баруун талаас эхэлж Хөгнө хаан уулын баруун талаар сунаж тогтсон 80 километр орчим урт элсэн манхан юм. Төв зам энэ элсэн манханг хувааж байдаг бөгөөд өмнө хэсгийг нь Монгол элс, хойд талыг нь Хөгнө тарнын элс гэж нэрлэдэг. Тарнын голын нөлөөгөөр элсэн доороо чийгтэй байх бөгөөд бургас, хайлаас, яргай зэрэг бутлаг ургамал ургана. Эргэн тойронд нь жуулчны баазууд байрлах бөгөөд хойд талд нь Хөгнө хаан хэмээх үзэсгэлэнт сайхан уул, урд талд нь Их Монгол хэмээх Монгол орны хүйс цэгийг баримжаалах уул оршино.

## ИХ БАГА МОНГОЛ УУЛ БОЛОН ШИРЭЭТ ЦАГААН НУУР

Өндөр гэгээний өргөөг барьж өнөөгийн Монгол улсын нийслэлийн шавыг тавин, өлзий буян дэлгэрсэн үзэсгэлэнт сайхан нутаг бол Монгол нутгийн хүйс их, бага Монгол уулын хооронд орших Монгол элсний Ширээт цагаан нуур юм. Өндөр гэгээний өргөөний анхны хэв загвар нь тооно, унь, хана, хаалга бүхий монгол гэрийн хэлбэрээр урлан бүтээсэн цагаан эсгий бүрээстэй дуган, түүнийг тойрсон жижиг сүм, суврага гэр тэргүүтэн байжээ. Тэр хүндтэй газар нутагт алтан шаргал өнгөт монгол элсний цагаан нуурын хөвөөг сонгосон нь тохиолдлын бус түүх уламжлал, төр ёс, билэгдэл байгаль экологийн учир холбогдолтой байжээ. Энэ нутаг нь хангай, говь завсрын бүсийн бүх шинжийг хадгалсан уул ус, нуур цөөрөм, рашаан булаг, цэцэг ногоо дэлгэрч арцны үнэр анхилсан монгол нутгийн тансаг бүхнийг агуулсан хосгүй сайхан нутаг юм. Эртний домог түүхтэй их, бага монгол уул Ширээт цагаан нуурыг ихэд хүндлэн арц үнэртнээр ариутган, тахилга хүндэтгэл үйлдсээр ирсэн түүхтэй. Эзэн Чингис хааны алтан ургийнхны төр ёсны уламжлал, билэгдэл, тэргүүлэх байр суурийг хадгалсаар ирсэн Орхон түшээ гүний сав нутагт Халхын Түшээт ханыхан улс төрийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, төр ёсныхоо уламжлалыг хадгалсаар ирсэн сурвалжит түүхтэй ажээ.

## ШАНХЫН ХИЙД

Их хүрээ Орхон голын хөндийгөөс Хэнтий уулын өвөр тийш нүүхэд номын хүрээний гол хэсэг мөн түүхийн эх сурвалж бичиг баримт судар түүх дурсгалын холбоотой үнэт зүйлүүдийг үлдээж нүүсэн байна. Энэ цагаас эхлэн баруун талд үлдсэн хийдийн гол хэсгийг олны дотор /Баруун хүрээ/ хэмээн нэрлэх болжээ. Энэ нь бас Шанх уулын өвөр талд байрших болсноор Шанхын хүрээ гэж хожим нэрлэгджээ.



# БУСАД ҮЗМЭРҮҮД

## ХУЖИРТ РАШААН

Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг, Орхон голын сав газарт, Хангайн нурууны салбар Шунхлай, Гуа, Шивээт уулсын дунд далайн төвшнөөс дээш 1600 метрт, Улаанбаатараас 390 км-т оршдог. Карбонат-сульфат-натри-кальцийн найрлагатай, фторт азотын халуун рашаан бөгөөд үе мөч, арьсны өвчин, ясны гэмтэл, эмэгтэйчүүд, мэдрэлийн өвчний үед голдуу хэрэглэнэ. Мөн эмчилгээний хүчийн зүйлийн нэг бол лаг хар шавар бөгөөд үе мөч болон арьсны зарим өвчний үед хэрэглэнэ. Эмчилгээг шавраар, усаар, зүүгээр, бариа заслаар, мөн физик эмчилгээний аргаар зохион байгуулдаг. Тархины судасны хатуурлын гүнзгийрсэн хэлбэр, дахилттай болон хүндрэлтэй явцтай өөрөөр хэлбэл, кардиогены шок, хүнд хэм алдагдал, зүрхний шигдээсийн дараах үе, артерийн даралт ихдэлтийн өвчин ИБ түүнээс дээд шат, зүрхний бахын байнгын болон хүнд хэлбэрийн илэрлийн үед энэ рашаан зохимжгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Хужирт рашаан сувилал нь байнгын ажиллагаатай бөгөөд нэг ээлжиндээ 350-600 хүн хүлээн авах хүчин чадалтай.

## МОНГОЛ ОРНЫ ТӨВ ХҮЙС

Монгол орны өнөөгийн газар нутгийн “Хүйс цэг” нь газар зүйн солбилцлын аргаар олсон Х.Ө 460521, З.У1030501-т орших Өвөрхангай аймгийн Бүрд сумын “Өвөр хөшөөтийн булаг” юм. Монгол орны төв цэгийн байршлыг газар зүйн ШУ-ны доктор, профессор, Монгол Улсын гавьяат багш Ш.Шагдар 1979 онд анх судлан тодорхойлсон байдаг. Улмаар Өвөрхангай аймгийн ИТХ-ын 1997 оны 42 дугаар тогтоолоор 8.2 км<sup>2</sup> талбайг хамруулан аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг болгосон. Монгол нутгийн хүйс төв цэгийн байршилтыг тогтоохдоо дараах дөрвөн аргаар тодорхойлжээ. “Хүйс цэг” нь Өвөрхөшөөтийн булгийн эхэнд д.т.д 1730м өндөрт Өвөрхангай аймгийн төвөөс зүүн хойш 115 км, эртний нийслэл Хорхорумаас зүүн урагш 85 км, Монгол Улсын нутгийн захын цэг “Модот хамар”, баруун захын цэг “Мааньт” уулнаас тус тус 1222 км орчим, хойд захын цэг “Монгол шарын даваанаас 670 орчим км, өмнөд захын цэг “Орвог гашууны бор толгой”-гоос 600 гаруй км зайтай оршдог. Мөн дэлхийн экватораас хойш 5194 км, хойд туйлаас ургаш 4808 км орчим зайтай оршиж, дэлхийн цагийн 7-р бүсэд хамаардаг

## ҮҮРТИЙН ТОХОЙ


Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын төвөөс зүүн хойш 18 километрт Улаанбаатар хотоос Орхоны хүрхрээ хүрэх зам дагуу бас нэгэн гайхамшигт ханан хад бүхий хавцлыг Үүртийн тохой гэдэг. Далайн түвшнээс дээш 1630 метр өндөрт. Энд дотрын өвчинд тустай нүүрсхүчлийн хий бүхий исгэлэн хүйтэн рашаан байдаг. Анх Үүртийн тохой гэдэг нэртэй байсан бөгөөд Галдан хааны цэргүүд Өндөр гэгээн Занабазарыг барихаар Төвхөн хийдэд ирэх замд нь Орхон гол гэнэт үерлэн Галдан бошигтын цэргүүд олноороо усанд үйж үхэн. Үхсэн цэргүүдийн хүүр Үүртийн тохойд овоорон гарч ирсэн тул Үүртийн тохой гэж нэрлэжээ. Энэ хэллэг сунжирсаар Үүртийн тохой болсон гэх. Энэ үйл явдлын дараа Манжийн хаан Өндөр гэгээн Занабазарыг аварсан Орхон голд “Түшээ гүн” цол олгож, Улаан цутгалангийн тогоонд жил бүр 100 лан цагаан мөнгө өргөж байх зарлиг гаргасан хэмээдэг. Орхон гол (түшээ гүн) нь Улаан эргийн тохойгоос Үүртийн тохой хүртэл тасралтгүй 10-25 метрийн өндөр хавцлаар 60 гаруй километр зам туулан урсдаг. Монгол орны хамгийн урт гол юм.



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД



ЭЛСЭН ТАСАРХАЙ ОРЧМЫН БААЗУУД



## ХОЁР ЗАГАЛ

- 📍 Өвөрхангай аймгийн Бүрд сум
- ☎ 88011051  
70326598
- 🌐 [www.arvaikheerpalace.mn](http://www.arvaikheerpalace.mn)
- 📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



## БАЯН ГОВЬ

- 📍 Өвөрхангай аймгийн Бүрд сум
- ☎ 70323131  
91040244
- 🌐 [www.bayangobi.mn](http://www.bayangobi.mn)
- 📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



## SWEET GOBI

- 📍 Өвөрхангай аймгийн Бүрд сум
- ☎ 70322230  
99016806
- 🌐 [www.sweetgobi.mn](http://www.sweetgobi.mn)
- 📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД

## АРВАЙХЭЭР ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



### НОМАДИК

📍 Өвөрхангай аймгийн  
Арвайхээр хот

☎ 9811-7456

📘 Монгол, Европ, Ази хоол  
[www.facebook.com/nomadic](http://www.facebook.com/nomadic)

📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ГЭРЭЛ

📍 Өвөрхангай аймгийн  
Арвайхээр хот

☎ 9901-7079

📘 Монгол хоол  
[www.facebook.com/gerel](http://www.facebook.com/gerel)

📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### АЛТАН НУТАГ

📍 Өвөрхангай аймгийн  
Арвайхээр хот

☎ 9999-7268

📘 Пицца хүргэлт  
[www.facebook.com/altannutag](http://www.facebook.com/altannutag)

📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## ТҮМЭН САРЛАГИЙН БАЯР

Энэхүү арга хэмжээ нь гадаад дотоодын жуулчдын сонирхлыг зүй ёсоор татаж, улмаар тэдэнд үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, сарлагийн гаралтай түүхий эдийн ашиг шимийг сайжруулах, сурталчлах зорилготойгоор зохион байгуулагддаг юм.

### ХУГАЦАА:

Жил бүрийн 7-р сарын 23-ны өдөр

### ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум, Орхоны Хүрхрэнээс баруун хойш 8 км-т Өндөр-Хясаа хэмээх газар Сарлагын баяраар дараах төрлийн тэмцээнүүд явагддаг байна.

- Багийн тэмцээн
- Сарлаг бугуйлдах
- Дүүгүүр шидэх
- Сарлаган поло тоглох
- Сарлагийн шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах
- Сарлаг булгиулах
- Сайхан сарлаг шалгаруулах



## ТЭМЭЭНИЙ БАЯР

“Тэмээний баяр” эвент арга хэмжээ нь Тэмээн сүргийн тоо толгойг өсгөх, тэмээг гадаад, дотоодод сурталчлах, тэмээн сүргээр дамжуулж өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн болон ойролцоох сумдын тэмээчдийг уулзуулж туршлага судлах зорилгоор зохион байгуулж байгаа юм.

Дараах арга хэмжээнүүд зохион байгуулагддаг

- Тэмээний уралдаан
- Торомны уралдаан
- Сайхан тэмээтэй хос
- Сайхан буур
- Сайхан ингэ
- Тэмээн поло
- Сүү сүүн бүтээгдэхүүний үзэсгэлэн



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## АДУУЧДЫН БАЯР

### ХУГАЦАА:

Жил бүрийн 6 сард

### ЭВЕНТ БОЛОХ ГАЗАР:

Хотонт сумын төвөөс 53 км  
Торгоны зам-Хархорум хот  
наадам

Монгол улсын төдийгүй хүн төрөлхтний хосгүй үнэт өвд бүртгэгдсэн Эзэнт гүрний нийслэл Хархорум хот, Чингис хааны алтан ургийн хаад байгуулан өнөөдрийг хүртэл үнэт чанараа хадгалан ирсэн цөөн дурсгалын нэг болох Эрдэнэ-Зуу хийдийн үнэт өвийг урлаг, соёл, уламжлалт зан үйл, нүүдэлчдийн түүхийг өв соёлоор дамжуулан сурталчлахад чиглэгдсэн.

### ХУГАЦАА:

Жил бүрийн 7 сард

### ЭВЕНТ БОЛОХ ГАЗАР:

Хархорин сум



## УЛААН ЦУТГАЛАН, МӨСНИЙ АВИРАЛТ

Өвлийн аялал спортыг хөгжүүлэн дэмжих зорилгоор Монголын Уулын Хөтөчдийн холбоо, Адал явдалт аяллын Монголиа Экспедишнс компани зэрэг хувийн байгууллага болон клубууд хамтран зохион явуулдаг. Монголын уулчдын техник ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, шинэ залуу уулчдыг бэлтгэх, мөсөн хананд авирах спортыг Монголдоо хөгжүүлэх зорилгоор хамтран зохион байгуулдаг мөсөн хананы авиралтын сургалт юм

### ХУГАЦАА:

Өвлийн уриралд

### ЭВЕНТ БОЛОХ ГАЗАР:

Улаан цутгалан хүрхрээ  
Бат-Өлзий сумын төвөөс  
27 км



### 1 ДАХЬ ӨДӨР

#### ЭЛСЭН ТАСАРХАЙ ЭЛС - ТЭМЭЭ УНАХ

Бид таныг 08:00 цагт байрлах байрнаас чинь аваад Элсэн Тасархай (285 км - хатуу хучилттай замаар 4 цаг) руу явна. Элсэн тасархай нь говийн хойд зах гэж үздэг бөгөөд энэ нь жижиг элсэн манхан бөгөөд домогт Хөгнө Хаан, Бат Хааны нурууны нам дор байдаг. Энд тэмээ унах болно (1 цаг). Хоёр бөхт тэмээ удаан, зөөлөн алхдаг тул тэдний дунд тухтай сууж, бөгтөрүүд бидэнд сайн дэмжлэг үзүүлэх тул морь унахад маш тохь тухтай байдаг. **Хоноглох:** Жуулчны бааз, гэр буудал, майхан

### 2 ДАХЬ ӨДӨР

#### НАЙМАН НУУР - МОРИН АЯЛАЛ

Өглөөний цайны дараа бид Найман нуур руу явна (245 км - хатуу хучилттай замаар 7 цаг). Найман нууруудын бүсэд янз бүрийн өнгөөр ялгагдах дээд хэмжээний 8 тогоруу нуур багтана. Ширээт нуур нь хамгийн том бөгөөд бусад нууруудын хамгийн өмнөд хэсэг юм. Үдийн хоолны дараа бид морин аялалаа эхлүүлнэ. Морь унах дуртай хүн модлог нуруу, уулын нуга дунд мартагдашгүй аялал хийх болно. Морины багцын аялал нь өмнөд монголын цөл газарт гүн гүнзгий нэвтрэх боломжийг олгодог. Шөнөдөө майханд хоноглоно. **Хоноглох:** Майхан

### 3 ДАХЬ ӨДӨР

#### МОРИН АЯЛАЛ БОЛОН УЛААНЦУТГАЛАН

Өглөөний цайны дараа бид морьтой аялалаа үргэлжлүүлэн Орхоны хүрхрээ рүү явна (бүтэн өдрийн аялал). 25 м-ээс дээш өндөр, 10 м өргөн Орхоны хүрхрээ нь тус улсын хамгийн том хүрхрээ бөгөөд ЮНИСКО-гийн дэлхийн өвд бүртгэгдсэн Орхон голын хөндий дэх хамгийн үзэсгэлэнтэй газруудын нэг юм. Хүрхрээ орчмын газрууд нь ойролцоогоор 20,000 жилийн тэртээх галт уулын нөлөөгөөр үүссэн бөгөөд 10 м-ээс дээш зузаантай лаав давхаргаар бүрхэгдсэн байв. **Хоноглох:** Жуулчны бааз, гэр буудал, майхан

### 4 ДАХЬ ӨДӨР

#### ТӨВХӨН ХИЙД

Өглөөний цайны дараа бид Төвхүн сүм рүү (60 км - шороон замаар 2 цаг) явна. Энэхүү хийд нь 2000 метрийн өндөрт, өтгөн ой модтой, үзэсгэлэнтэй Шивээт уулын оргил дээр байрладаг. Монголчуудын анхны богд (Буддын шашны тэргүүн) Занабазарын дагалдагчид уг сүмийг 1653 онд бясалгал, урлагийн студийн зорилгоор барьжээ. Үзэх сонирхолтой хэд хэдэн зүйл байна. Бясалгалын агуй, хадан дээрх Занабазарын хөлийн хэвлэмэл зураг, соёмбын анхны зурсан хувилбар, тусгаар тогтнолын бэлгэдэл гэх мэт. Бид уулын ёроолоос орой буюу хийд хүртэл явган аялал хийнэ.

### 5 ДАХЬ ӨДӨР

#### КАРАКОРУМ - ЭРТНИЙ НИЙСЛЭЛ


Өглөөний цайны дараа бид Каракорум руу явна (125 км - хатуу хучилттай замаар 2 цаг). Өнөөдөр нутгийн жижиг суурин газар байдаг ч энэ газар нь цагтаа Их Монгол Улсын нийслэл Каракорум байсан юм. 200 жилийн дараа хятадууд эвдэн сүйтгэснээс хойш 1586 онд баригдсан Эрдэнэ зуу нь Монголд баригдсан Буддын шашны анхны хийд бөгөөд барилгын янз бүрийн материалыг Каракорумын тууриас авчээ. Бид Эрдэнэ зуу хийд, Каракорум музей болон бусад сонирхолтой түүхэн дурсгалт газруудаар зочлох болно.

**Хоноглох:** Зочид буудал, жуулчны бааз, гэр буудал, майхан

### 6 ДАХЬ ӨДӨР

#### УЛААНБААТАР РУУ БУЦАХ

Өглөөний цайны дараа бид Улаанбаатар хот руу (360 км - хатуу хучилттай замаар 6 цаг) явна. ТӨГСГӨЛ. Дуусах цаг: 16:00 цаг орчим  
Нийт зай: 1200 км (+ 200)



#### ЖИШЭЭ ХӨТӨЛБӨР

- Өдөр1. Элсэн Тасархай
- Өдөр2. Найман нуур ба морин аялал
- Өдөр3. Морин аялал
- Өдөр4. Орхоны хүрхрээ ба Төвхөн хийд
- Өдөр5. Каракорум

# ОРХОНЫ ХӨНДИЙН АЯЛАЛЫН МАРШРУТ